



МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу, Засгийн газрын IV байр,  
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2014.04.30 № 05/41 ЧАТ-САТ/2014/05-СМА-ТНС

Зөрчил арилгуулах тухай

Хөдөлмөрийн яамны харьяа Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2013 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- 2013 оны батлагдсан төсөвт хөрөнгө оруулалтын зардалд тусгагдаагүй боловч тухайн сангийн удирдах зөвлөлийн хурлаар 409,901,921.0 төгрөгийг Хөдөлмөрийн яамны их засварын зардалд зарцуулахаар шийдвэрлэж Хөдөлмөрийн сайдын 2013 оны А/28 дугаар тушаалын дагуу нэмэлт санхүүжилтийг баталж, зарцуулсан,
- 2013 оны батлагдсан төсөвт хөрөнгө оруулалтын зардал тусгагдаагүй боловч тухайн сангийн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэж 200.0 сая төгрөгийн автомашины зардлыг Хөдөлмөрийн сайдын 2013 оны А/28 дугаар тушаалын дагуу нэмэлт санхүүжилтээр баталж, худалдан авсан бөгөөд тайлант онд бэлтгэсэн 2 ширхэг автомашины нэг болох 35,000,000.0 төгрөгийн өртөгтэй KIA OPTIMA 04-20 УНУ автомашин нь тухайн сангийн хөрөнгөд бүртгэлтэй боловч Хөдөлмөрийн яамны үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа,
- Төсвөөр батлагдсан орон тоог хэтрүүлэн ажилласантай холбоотой удирдах зөвлөлийн гишүүдийн цалинд 30,605,760.0, сайдын зөвлөх болон гэрээт ажилтан 4 хүний цалинд 34,198,125.0, нийт **64,803,885.0** төгрөгийг төсөвт зардлаас хэтрүүлэн олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д: "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", ЗГТС-гийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1-д: "тусгай сангийн хөрөнгийг батлагдсан төсвөөс хэтрүүлэх, хуульд зааснаас өөр зориулалтаар ашиглах, зарцуулахыг хориглоно", ЗГТС-гийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3-д: "энэ хуулийн 6.4-т заасан тусгай сангийн зохион байгуулалт, орон тооны хязгаарыг Засгийн газар тогтоох бөгөөд хөрөнгийг нь захиран зарцуулах шийдвэрийг тухайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн гаргана" гэснийг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т: "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх...", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан "төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3.1.1-д ".....алдаа зөрчлийг арилгуулахаар төрийн аудитын байгууллага холбогдох албан тушаалтанд албан шаардлага өгнө" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Дээрх зөрчлийг таслан зогсоож, сангийн хөрөнгийг холбогдох хууль тогтоомж, зохих заавар, журмын дагуу зарцуулж байх
2. Албан шаардлагаар өгсөн үүргийн биелэлтийг 2014 оны 12 дугаар сарын 1-ний дотор УАГ-т ирүүлэхийг ЖДҮХС-гийн захирал Б.Баттүвшин, СААТБХ-ийн дарга Ч.Цасчихэр нарт хариуцуулав.

АУДИТОР

П.ЧАНЦАЛДУЛАМ